



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/175

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Монголын хүүхдийн волейболын академийн 14 насны шигшээ багийн тамирчин Тэгшбаярын Нандин-Эрдэнэ нь Чех улсын Праг хотноо зохион байгуулагдаж буй PRUGUE VOLLEYBALL GAMES WINTER-2023 Олон Улсын тэмцээнд оролцож байгаа тул дэмжлэг үзүүлж, Хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих арга хэмжээний зардлаас 500,000 (таван зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Арга хэмжээний төсвийн дагуу 500,000 (таван зуун мянга) төгрөгийг Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийн зардлаас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг хангаж зарцуулахыг нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА